

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл:

- ☒ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан
шинэчлэн боловсруулсан
- ☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

2023.12.27

А/401

Байгууллагын нэр:

Экологийн цагдаагийн алба

Нэгжийн нэр:

Дүн шинжилгээ, хяналт шалгалтын хэлтэс

Албан тушаалын нэр:

Хяналт шалгалт хариуцсан ахлах
байцаагч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТТ-5

Ажлын цаг:

8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Сүхбаатар дүүрэг, 7 дугаар хороо,
Эрхүүгийн гудамж-6

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Байгалийн гамшиг, гал түймэр, хүн, малын гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн болон бусад аюул тохиолдсон, нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага, онц болон дайны байдал зарласан, онц ноцтой гэмт хэрэг үйлдэгдсэн зэрэг зайлшгүй тохиолдолд уртасгасан цагаар болон өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах.

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ:

Албан тушаалын зорилго:

Байгууллага, алба хаагчийн дотоод аюулгүй байдлыг хангах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, алба хаагчийн сахилга, хариуцлага, ёс зүйн байдалд хяналт тавьж, албаны бүтцийн нэгж, аймаг дахь цагдаагийн газар, хэлтсийн экологийн асуудал хариуцсан алба хаагчдын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулж, илэрсэн зөрчил, дутагдлыг засуулах, дахин зөрчил дутагдал гаргахаас урьдчилан сэргийлэх.

Албан тушаалын зорилт:

- 1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, хөтөлбөр, төлөвлөгөө байгууллагын үйл ажиллагаатай холбогдуулан дээд шатны удирдах албан тушаалтнаас өгсөн үүрэг, даалгавар, ажлын чиглэлийг албаны хэмжээнд зохион байгуулж, хэрэгжүүлэх;
2. Байгууллага, алба хаагчийн аюулгүй байдлыг хангах, зөрчигдсөн эрх ашгийг хамгаалах чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээг зохион байгуулж, биелэлт үр дүнг тооцох.
3. Алба хаагчдын сахилга, ёс зүйн байдалд өдөр тутам хяналт тавьж, сахилга, ёс зүйн зөрчил гаргасан алба хаагчдад албаны шалгалт явуулж, саналыг албаны удирдлагад танилцуулан, дүнг холбогдох газарт хүргүүлж, дахин зөрчил дутагдал гаргахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр ажил, арга хэмжээ зохион байгуулах, үр дүнг тооцох,
4. Албаны бүтцийн нэгжийн болон аймаг дахь цагдаагийн газар, хэлтсийн экологийн асуудал хариуцсан алба хаагчдын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулж, илэрсэн зөрчил, дутагдлыг засуулах, шалтгааныг тогтоож, цаашид авч хэрэгжүүлэх, арга хэмжээний саналыг тодорхойлох;
- 5.Хууль тогтоомж, дүрэм журмаар хүлээлгэсэн албан тушаалын зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах –Т, Харилцан, гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.1.Монгол Улсын хууль, тогтоомж, эрх зүйн зүйн акт, дээд байгууллага албан тушаалтнаас гаргасан баримт бичиг, үүрэг чиглэлийг хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг зохион байгуулж, хэлтсийн даргын өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх; 1.2.Албаны дарга болон бусад удирдах албан тушаалтнаас өгсөн үүрэг, даалгавар ажлын чиглэлийг хэрэгжүүлж, биелэлтийг нэгтгэн танилцуулах.	Байгууллагын үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдаж үр дүнд хүрсэн байна. Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаварын хэрэгжилт хангагдана.	Г Г,Х
2 дугаар зорилтын хүрээнд	2.1.Байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах чиглэлээр Цагдаагийн ерөнхий газрын төлөвлөгөөнд нийцүүлэн ажил, арга хэмжээг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэн, биелэлт, үр дүнг тооцон холбогдох газарт хүргүүлэх; 2.2. Байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах төлөвлөгөөнд заасан алба хаагчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр ажил, арга хэмжээ зохион байгуулж, биелэлт үр дүнг тооцох. 2.3.Байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр, шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах, ажлыг гүйцэтгэх, удирдлагад танилцуулж шийдвэрлүүлэх;	Байгууллагын дотоод аюулгүй байдал хангагдаж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлсэн байна.	Г,Х Г,Х Г,Х

	2.4.Эрсдэлийн удирдлагатай холбоотой дүрэм журам аргачлалыг үйл ажиллагаанд хэрэгжүүлж ажиллах; 2.5.Эрсдэлийн удирдлагын менежментийн төлөвлөгөөг боловсруулж, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх тодорхой ажил, арга хэмжээг зохион байгуулж, удирдлагыг мэдээллээр хангаж, арга хэмжээ авах; 2.6.Байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, хүн малын гоц халдварт өвчин гарсан үед ажиллах үүргийг хэрэгжүүлэх ажлыг төлөвлөх, боловсронгуй болгох, хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж, биелэлтийг холбогдох газарт хүргүүлэх. 2.7. Алба хаагч, ажилтны эрх ашгийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх талаар ажил, арга хэмжээг зохион байгуулж, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтэстэй хамтран ажиллах.		Г,Х Г, Х Г, Х Г, Х
3 дугаар зорилтын хүрээнд	3.1.Алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрмийг мөрдүүлэх, сахилга, ёс зүйг дээшлүүлэх, бэхжүүлэх чиглэлээр удирдах албан тушаалтнаас өгсөн үүрэг, албан даалгаврыг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих; 3.2.Сахилга, ёс зүйн байдалд дүн шинжилгээ хийж, түүнийг бэхжүүлэх, сайжруулах, зөрчил дутагдал гаргахаас урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжүүлэх, хяналт тавих; 3.3.Албаны хэмжээнд алба хаагчдын сахилга, ёс зүйн байдал, албаны шалгалт, алба хаагчтай холбоотой иргэд, байгууллагаас гаргасан өргөдөл, гомдлын мэдээг сар бүр нэгтгэж, холбогдох нэгжид хүргүүлэх, хяналт тавих; 3.4.Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын "Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах /код 112/ журам"-ыг мөрдөж ажиллахдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-дахь хэсэг, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.3 дугаар зүйлд заасан эрх эдлэх.	Алба хаагчдын сахилга, ёс зүй төлөвшиж албаны нэр хүнд дээшилнэ.	Г,Х Г,Х Г,Х Г,Х

	3.5. Гэмт хэргийн шинжтэй өргөдөл, гомдол, эрүүгийн хэргийг мөрдөн шалгах ажиллагааны явцад ирүүлсэн прокурорын шаардлага болон албан бичгийг бүртгэлд авч, шаардлагатай үед албаны шалгалт явуулж, дүнг удирдлагад танилцуулан дахин зөрчил гаргахаас урьдчилан сэргийлж, үүрэг, ажлын чиглэл, зөвлөмж хүргүүлж, биелэлт үр дүнг тооцох; 3.6.Сахилга, ёс зүйн зөвлөгөөнийг зохион байгуулж, дүнг танилцуулах.		Г, Х
4 дүгээр зорилтын хүрээнд	4.1. Цагдаагийн төв байгууллага болон албаны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд уялдуулан нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хяналт шалгалтын чиглэлээр тусгуулах ажлын саналыг өгч, хийсэн ажлын тайланг хэлтсийн дүн шинжилгээ, үнэлгээ хариуцсан чиглэлийн ахлах, ахлах албан тушаалтанд хугацаанд нь гарган өгөх. 4.2. Нэгжүүдийн үйл ажиллагаа, алба хаагчийн үүрэг гүйцэтгэлийн байдалд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, дүнг танилцуулж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх; 4.3.Гүйцэтгэх ажил, ажилтны үйл ажиллагаатай холбоотой гомдол мэдээлэлд шалгалт хийж, дүнг, удирдлагад танилцуулах.	Үйлчилгээний стандарт хэрэгжиж, ажлын үр дүн, алба хаагчдын хуульч ажиллагаа дээшилнэ. Нэгжүүдийн үйл ажиллагаа, алба хаагчийн ажлын чанар дээшилнэ.	Г,Х
5 дугаар зорилтын хүрээнд	5.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж, байгууллагын ажилтнууд болон харилцагч, үйлчлүүлэгчид, иргэдтэй зөв боловсон харьцах, ёс зүйн зөрчил, дутагдал гаргахгүй байх; 5.2.Авлига, хүнд суртлаас ангид байж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн.шударга ёсыг эрхэмлэн, "Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг чанд мөрдөх; 5.3.Явцуу эрх ашиг сонирхлоос татгалзаж, цагдаагийн байгууллага, албаны нийтлэг эрх ашиг сонирхлыг эрхэмлэн ажиллах.	Цагдаагийн алба хаагчийн нийтлэг үүрэг, хууль тогтоомжоор хүлээлгэсэн бусад үүргийн биелэлт хангагдана.	Г

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА	
Боловсрол	Дээд боловсролтой, Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.
Мэргэжил	- Эрх зүй /0421/ - Аюулгүй байдал /1032/


Мэргэшил	Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх.	
Туршлага	-Цагдаагийн байгууллагад 6-аас доошгүй жил ажилласан, үүнээс нэгжийн ахлах болон түүнтэй адилтгах албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх.	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	-Мэдээллийн үнэн, бодит байдлыг шалган нягтлах; -Нарийн төвөгтэй мэдээллийг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тодруулах; -Байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх; -Судалгааны арга зүйн мэдлэгтэй.
	Асуудал шийдвэрлэх	-Өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах; -Асуудал шийдвэрлэх эдийн засаг, хууль зүйн үндэслэлийг тодорхойлох; -Удирдлагын өгсөн чиглэлийн дагуу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээг зохион байгуулах.
	Багаар ажиллах	-Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; -Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох.
	Бусад	-Албан хэрэг хөтлөлт боловсруулах, монгол хэл, бичгийн дүрэм, үг зүй, найруулга зүйн зохих мэдлэгтэй байх; -Компьютерын Microsoft Office Word, Microsoft Office Excel, Microsoft Office Power Point программуудыг хэрэглээний түвшинд ашиглах чадвартай байх; -Нууц хадгалах.

IV. АЛБАН ТУШААЛЫН ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: Дэд бөгөөд Дүн шинжилгээ, үнэлгээ, хяналт шалгалтын хэлтсийн дарга	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект: Шууд харилцах байгууллага: -Хариуцсан асуудлаар бусад яам, агентлагийн албан тушаалын адил болон түүнээс доош зэрэглэлтэй албан тушаалтан; Шууд бус харилцах байгууллага: -Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хуулийн этгээд, иргэн; /Эдгээртэй харилцахдаа Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж, үйл ажиллагааны журмын холбогдох заалтыг баримтална/.

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ:

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
---	--

Албан тушаал: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА  Т.ГАНЗОРИГ 2023 оны <u>12</u> дугаар сарын <u>25</u> ны өдөр	Байгууллагын нэр: Шийдвэрийн огноо: Дугаар:
--	---

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:	
Байгууллагын нэр: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР Шийдвэрийн огноо: 2023.12.27 Дугаар: <u>А/401</u>	 ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА Т.СҮХБОЛД 2023 оны <u>12</u> дугаар сарын <u>27</u> ны өдөр

ТАНИЛЦСАН:

Албан тушаалтан:
2023 оны дугаар сарын-ны өдөр